



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 49

Эрдэнэт

“Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах,
бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас
хасах журам” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, 24, 25, 29, 30, 31 дүгээр зүйл, Засгийн газрын 2008 оны 148, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д, мөрдөж ажиллахыг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 157 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА П.ПҮРЭВЛХАГВА